



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/137

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.2. "а", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны "Аймгийн 2020 оны төсөв батлах тухай" 12/09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны "Аймгийн төсөв батлах тухай" 12/09 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан "2020 онд аймгийн төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, жагсаалтын 2 дахь заалтын дагуу Тарагт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын автомашины засварын зардалд 3000000 (гурван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардал 3000000 (гурван сая) төгрөгийг 2020 оны аймгийн төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100297